БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/76/СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424,88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг:tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор хот 2019 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| СДЭ | Сум дундын эмнэлэг |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ..... 3

2 Аудитын тайлан ..... 5

2.1 Оршил ..... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 8

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 8

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 9

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 9

2.8.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал ..... 9

2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 10

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10

байхгүй ..... 10

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 10

2.11 Шилэн дансны мэдээлэл ..... 11

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 11

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 11

3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 12

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 12

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.12 № 2/09

танай ___________-ны № ________________ т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН СУМ
ДУНДЫН ЭМНЭЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.ОДОНТУНГАЛАГ ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Сум дундын эмнэлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Сум дундын эмнэлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

2019 on gerchilgee.Bayantsagaan Sum dundiin emneleg .docx

2518481

Аудитаар Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Сум дундын эмнэлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

2019 on gerchilgee.Bayantsagaan Sum dundiin emneleg .docx

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эмнэлгийн эрхлэгч Одонтунгалагт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.20-ноос 2019.01.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.19-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг нь Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй чанартай үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Баянхонгор Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн “Эмч эмнэлгийн ажилтны ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах жилийн хүрээнд эмнэлгийн ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулж, ард иргэдэд орчины эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих сургалт сурталчилгааг эрчимжүүлэн, урьдчилсан сэргийлэх үзлэгт иргэдийг бүрэн хамруулах .” зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох програм” хангамж ашигладаг байна.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитын явцад Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2018 оны нийт зардал 472094,0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 9441,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

### 2.8.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал

Ажиллагсадын 1, 7-р сарын цалингаас суутгасан ҮЭ-ийн татварын 292,8 мянган төгрөгийг ҮЭ-ийн хорооны дансанд төвлөрүүлээгүй, мөн 2-р сарын цалингаас НДШ-ийн 19,5 мянган төгрөгийг илүү суутгасан атлаа тайланд өглөгөөр тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 "Нягтлан бодох бүртгэлд бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад хийсэн дээрх залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудал байхгүй.

## 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

байхгүй

## 2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 407637,6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 399210,8 мянган төгрөг буюу 97,9 хувьтай байгаа нь тайлант хугацаанд зарцуулагдаагүй үлдэгдэл 8412,6 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг өмнөх он болон батлагдсан төсөвтэй харьцуулахад өмнөх оноос батлагдсан төсөв 32.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлээр 24.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.Тайлант онд улсын төсвөөс 367,6 сая, ЭМДС-аас 40,0 сая төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж, санхүүжилтийг бүрэн авч зарцуулагдаагүй үлдэгдэл 8,4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Төсвийн зарлагын гүйцэтгэлийг өмнөх он болон батлагдсан төсөвтэй харьцуулахад зардал өмнөх оноос 35,6 сая төгрөгөөр, гүйцэтгэлээр 23,7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 407,6 сая төгрөгийг зарцуулахаар төсөв батлагдаж 399,2 сая төгрөгийг зарцуулан 8,4 сая төгрөгийг хэмнэсэн байна. Энэ нь цалингийн зардал 2,0

сая, НДШ 0,2 сая, бараа үйлчилгээний бусад зардал 6.2 сая төгрөгөөр зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

### 2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 оны 11 дүгээр сарын 20-д хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 24 мэдээллийг хугацаанд нь 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий 64 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн.

### 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянцагаан сумын Сум дундын эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А / төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **25,962,398.54** | **31,182,670.54** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 25,962,398.54 | 31,182,670.54 |
| **354** | **Хангамжийн материал** | 22,452,398.54 | 27,672,670.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 345,650.00 | 345,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,176,277.00 | 13,076,277.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 410,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,589,300.00 | 1,589,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,341,171.54 | 12,251,443.54 |
| 35600 | Мал амьтад | 3,510,000.00 | 3,510,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **125,946,084.09** | **376,351,374.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 125,946,084.09 | 376,351,374.03 |
| **392** | **Биет хөрөнгө** | 125,946,084.09 | 361,853,374.03 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 180,383,449.00 | 275,786,430.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -151,991,987.39 | -120,000.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 57,868,002.00 | 62,848,002.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -23,404,810.98 | -34,575,676.54 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 171,097,858.62 | 185,717,943.72 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -114,318,154.77 | -132,770,861.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,982,615.90 | 14,982,615.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,670,888.29 | -10,015,079.89 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 14,498,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 450,000.00 | 14,948,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **151,908,482.63** | **407,534,044.57** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **312,368.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 312,368.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 312,368.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **151,908,482.63** | **407,221,676.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 151,908,482.63 | 407,221,676.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 270,954,863.00 | 285,452,863.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 270,954,863.00 | 285,452,863.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -187,721,240.37 | -206,245,546.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -187,721,240.37 | -187,721,240.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -18,524,306.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 68,674,860.00 | 328,014,360.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **151,908,482.63** | **407,534,044.57** |

### 3.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А төгрөг

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **418,553,102.78** | **453,569,759.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **548,254.54** | **8,839,818.08** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 548,254.54 | 2,239,732.98 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 548,254.54 | 1,410,132.98 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,860.00 | 12,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 543,394.54 | 1,398,132.98 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 829,600.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 6,600,085.10 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 6,600,085.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **418,004,848.24** | **444,729,941.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 345,498,300.00 | 367,623,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 345,498,300.00 | 367,623,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,933,052.00 | 37,118,532.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,933,052.00 | 37,118,532.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 36,974,716.24 | 00.00 |
| 133003 | Хөрөнгийн | 36,974,716.24 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 29,598,780.00 | 39,988,209.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 39,988,209.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 29,598,780.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **438,265,234.07** | **471,719,390.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **438,265,234.07** | **471,719,390.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 423,323,384.07 | 426,188,255.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 266,533,865.00 | 279,490,282.00 |
| 210101 | Үндсэн цалин | 202,463,853.00 | 189,102,357.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,697,216.00 | 73,507,596.00 |
| 210104 | Урамшуулал | 17,372,796.00 | 16,880,329.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,424,324.00 | 33,508,455.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,424,324.00 | 30,311,818.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 796,760.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 643,167.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 163,191.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 1,593,519.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,013,145.00 | 20,631,699.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,555,345.00 | 1,496,455.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10,252,000.00 | 19,024,124.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 205,800.00 | 111,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,582,003.80 | 19,898,390.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 844,500.00 | 1,337,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,422,824.00 | 15,692,930.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 108,900.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 347,400.00 | 982,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,858,379.80 | 1,885,360.98 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,361,788.00 | 37,129,004.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,462,888.00 | 31,249,304.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,145,300.00 | 5,144,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,753,600.00 | 735,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,157,600.00 | 1,042,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 201,500.00 | 119,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,956,100.00 | 923,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 518,000.00 | 658,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 518,000.00 | 658,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,091,100.00 | 2,404,987.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500.00 | 390,875.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,500.00 | 101,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,000.00 | 46,012.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 98,000.00 | 242,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 221,100.00 | 318,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 55,641,558.27 | 31,425,437.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,254,900.00 | 1,767,817.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 52,386,658.27 | 29,657,620.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,941,850.00 | 45,531,135.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,933,052.00 | 37,118,532.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,933,052.00 | 37,118,532.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,000,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,798.00 | 8,412,603.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,798.00 | 8,412,603.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-19,712,131.29** | **-18,149,631.47** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 374,674.74 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 374,674.74 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -374,674.74 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-19,712,131.29** | **-18,524,306.21** |

### 3.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-3А төгрөг

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **381,034,992.00** | **445,571,541.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,860.00** | **841,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,860.00 | 841,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,860.00 | 12,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,860.00 | 12,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 829,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **381,030,132.00** | **444,729,941.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 345,498,300.00 | 367,623,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 345,498,300.00 | 367,623,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,933,052.00 | 37,118,532.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,933,052.00 | 37,118,532.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 29,598,780.00 | 39,988,209.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 39,988,209.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 29,598,780.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **381,034,992.00** | **445,571,541.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **381,034,992.00** | **445,571,541.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **366,093,142.00** | **400,040,406.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 266,533,865.00 | 279,177,914.00 |
| 210101 | Үндсэн цалин | 202,463,853.00 | 188,789,989.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,697,216.00 | 73,507,596.00 |
| 210104 | Урамшуулал | 17,372,796.00 | 16,880,329.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,424,324.00 | 33,508,455.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,424,324.00 | 29,439,084.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,014,288.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 818,763.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 207,745.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 2,028,575.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,563,145.00 | 20,631,699.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,555,345.00 | 1,496,455.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,802,000.00 | 19,024,124.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 205,800.00 | 111,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,161,764.00 | 19,282,030.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 465,000.00 | 1,463,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,577,764.00 | 14,191,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 183,700.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 445,300.00 | 1,259,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 490,000.00 | 2,368,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,414,664.00 | 39,520,504.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,289,764.00 | 31,069,304.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,145,300.00 | 5,144,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,979,600.00 | 3,306,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,227,200.00 | 1,480,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 390,600.00 | 380,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,836,600.00 | 1,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 518,000.00 | 490,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 518,000.00 | 490,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,307,100.00 | 2,348,487.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 138,500.00 | 390,875.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 62,500.00 | 101,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,000.00 | 46,012.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 98,000.00 | 242,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 437,100.00 | 261,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,943,080.00 | 3,601,317.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,943,080.00 | 3,601,317.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,941,850.00** | **45,531,135.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,933,052.00 | 37,118,532.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,933,052.00 | 37,118,532.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,000,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,798.00 | 8,412,603.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,798.00 | 8,412,603.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А төгрөг

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **270,954,863.00** | **68,674,860.00** | **-187,721,240.37** | 151,908,482.63 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **270,954,863.00** | **68,674,860.00** | **-187,721,240.37** | 151,908,482.63 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 259,339,500.15 | 00.00 | 259,339,500.15 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 14,498,000.00 | 00.00 | -18,524,306.21 | -4,026,306.21 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **285,452,863.00** | **328,014,360.15** | **-206,245,546.58** | 407,221,676.57 |

## 3.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ төгрөг

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| **2** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 372,043,300.00 | 375,543,618.00 | 407,637,600.00 | 399,210,806.00 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 372,043,300.00 | 375,543,618.00 | 407,637,600.00 | 399,210,806.00 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 363,043,300.00 | 366,543,618.00 | 407,637,600.00 | 399,210,806.00 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 266,750,000.00 | 266,533,865.00 | 281,229,300.00 | 279,177,914.00 |
| 210101 | Үндсэн цалин | 200,079,000.00 | 202,463,853.00 | 185,625,000.00 | 188,789,989.00 |
| 210102 | Нэмэгдэл | 49,295,400.00 | 46,697,216.00 | 78,675,100.00 | 73,507,596.00 |
| 210104 | Урамшуулал | 17,375,600.00 | 17,372,796.00 | 16,929,200.00 | 16,880,329.00 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,874,800.00 | 29,874,800.00 | 33,747,500.00 | 33,508,455.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,874,800.00 | 29,874,800.00 | 22,498,300.00 | 29,439,084.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 2,812,300.00 | 1,014,288.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 2,249,800.00 | 818,763.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 562,500.00 | 207,745.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 5,624,600.00 | 2,028,575.00 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,579,700.00 | 11,563,145.00 | 22,414,400.00 | 20,631,699.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,480,700.00 | 1,555,345.00 | 1,733,000.00 | 1,496,455.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,893,200.00 | 9,802,000.00 | 20,041,400.00 | 19,024,124.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 205,800.00 | 205,800.00 | 640,000.00 | 111,120.00 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 12,166,400.00 | 12,161,764.00 | 19,717,700.00 | 18,987,230.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 466,800.00 | 465,000.00 | 1,466,800.00 | 1,463,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,580,400.00 | 10,577,764.00 | 14,244,900.00 | 13,896,630.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 183,700.00 | 183,700.00 | 240,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 445,500.00 | 445,300.00 | 1,306,000.00 | 1,259,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 490,000.00 | 490,000.00 | 2,460,000.00 | 2,368,400.00 |
| **2105** | Нормативт зардал | 38,079,000.00 | 37,414,664.00 | 40,342,300.00 | 38,985,704.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,953,100.00 | 30,289,764.00 | 31,716,400.00 | 30,534,504.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,145,900.00 | 5,145,300.00 | 5,145,900.00 | 5,144,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,980,000.00 | 1,979,600.00 | 3,480,000.00 | 3,306,500.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,232,600.00 | 2,227,200.00 | 1,600,000.00 | 1,480,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 396,000.00 | 390,600.00 | 400,000.00 | 380,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,836,600.00 | 1,836,600.00 | 1,200,000.00 | 1,100,000.00 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 531,300.00 | 518,000.00 | 531,300.00 | 490,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 531,300.00 | 518,000.00 | 531,300.00 | 490,000.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,334,500.00 | 1,307,100.00 | 3,105,100.00 | 2,348,487.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,500.00 | 500,000.00 | 250,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 138,600.00 | 138,500.00 | 515,000.00 | 390,875.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,200.00 | 62,500.00 | 160,000.00 | 101,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,700.00 | 33,000.00 | 72,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 1,306,800.00 | 1,306,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,000.00 | 38,000.00 | 110,800.00 | 46,012.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | 98,000.00 | 245,000.00 | 242,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 445,500.00 | 437,100.00 | 445,500.00 | 261,500.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 495000.00 | 4943080.00 | 4950000.00 | 3601317.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 495,000.00 | 4,943,080.00 | 4,950,000.00 | 3,601,317.00 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9000000.00 | 9000000.00 | 0.00 | 0.00 |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 9,000,000.00 | 9,000,000.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,000,000.00 | 9,000,000.00 | 00.00 | 00.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 376,498,300.00 | 375,093,142.00 | 407,637,600.00 | 399,210,806.00 |
| **1310** | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 345,498,300.00 | 345,489,502.00 | 367,623,200.00 | 359,210,597.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 345,498,300.00 | 345,489,502.00 | 367,623,200.00 | 359,210,597.00 |
| **1340** | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 29,600,000.00 | 29,598,780.00 | 40,014,400.00 | 39,988,209.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,600,000.00 | 29,598,780.00 | 40,014,400.00 | 39,988,209.00 |
| **120004** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,400,000.00 | 4,860.00 | 00.00 | 12,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000.00 | 4,860.00 | 00.00 | 12,000.00 |
| **62** | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 30 | 30 | 30 | 30 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 24 | 24 | 24 | 24 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05 | 05 | 05 | 05 |
| **65** | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | **30** | **13** | **30** | **30** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17 | 17 | 17 | 17 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13 | 13 | 13 | 13 |